



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гурвантэс сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ӨМА-2022/23/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.umnugovi@audit.gov.mn

Өмнөговь аймаг

2022 он

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: С.Цэрэнбаяр

Утас: 70533539 Цахим хаяг: Tserenbayars@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Хонгорзул

Утас: 88034203 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn

Аудитор: Э.Жаргал

Утас: 88025452 Цахим хаяг: jargale@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

Г УРВАНТЭС СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ЭРХЛЭГЧИЙН АЛБАН Г
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
У.НЯМСҮРЭН ТАНАА

2022-02-22 № 96

танай _____ -ны № _____ -т

Г _____ Г

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Гурвантэс сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гурвантэс сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

С.ЦЭРЭНБАЯР

D:\2021 Он\Бичиг Хэрэг\Явсан Бичиг\2022-02-22 №96\с

01001179



Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	<u>88,8</u>	<u>240,0</u>
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	<u>1,455,7</u>	<u>1,588,3</u>
	Нийт хөрөнгийн дүн	<u>1,544,6</u>	<u>1,828,3</u>
	Нийт өр төлбөрийн дүн	-	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	<u>1,544,6</u>	<u>1,828,3</u>
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	<u>1,544,6</u>	<u>1,828,3</u>
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	706,5	1,561,5
	Үйл ажиллагааны зардлын дүн	696,8	1,277,9
	Үйл ажиллагааны үр дүн	<u>9,7</u>	<u>283,6</u>
	Үйл ажиллагааны бус үр дүн	0,8	-
	Үйл ажиллагааны нийт үр дүн	<u>8,8</u>	<u>283,6</u>
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	962,5	1,544,6
	Тайлант оны үр дүн	283,6	283,6
	Эцсийн үлдэгдэл	<u>1,246,1</u>	<u>1,828,3</u>
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	<u>506,3</u>	<u>785,2</u>
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	<u>506,3</u>	<u>777,1</u>
	Үйл ажиллагааны ЦМГ	=	<u>8,1</u>
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-	7,9
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	0	0
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	0	0,01
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0,01
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	570,6	548,9
	Урсгал зардал	570,6	548,9
	Хөрөнгийн зардал	0	0
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	570,6	549,1
	Орон нутгийн төсвөөс	49,2	45,5
	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	471,4	471,4

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Гурвантэс сумын Эрүүл мэндийн төв нь "Ард иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай хүртээмжтэй хүргэж өвчлөлийг бууруулах" гэж зорилго тодорхойлон "Орчин үеийн оношилгоо эмчилгээний дэвшилтэт технологийн аргуудыг нэвтрүүлсэн урьдчилан сэргийлэх урьдчилан сэргийлэх цогц үйлчилгээтэй ёс зүйг дээдэлсэн жишиг эмнэлэг болох" гэж зорилт дэвшүүлсэн байна.

Гурвантэс сумын Эрүүл мэндийн төв нь харьяа нутаг дэвсгэртээ хүм амын эрүүл мэндийг хамгаалах чиг үүрэгтэй байгууллага байна.



Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг дараах хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хууль;

- Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” хүчингүй болж, 2021 оны 190 дүгээр тушаалаар шинэчлэн батлагдсан тушаалыг тайланд онд шинээр мөрдөгдөж байна.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

Аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй онцолсон бусад асуудал буюу Засгийн газрын 2021 оны 190 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой асуудал байна. Үүнд:

- Тус байгууллага нь бараа үйлчилгээний зардлаас вакум хаалга, эм худалдан авсан байна.

Дөрөв. Аудитын гол асуудал

Гурвантэс сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал байхгүй байна.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийсэн бөгөөд нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгаж тусгасан болно.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Гурвантэс сумын Эрүүл мэндийн төв нь 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 7 гүйлгээ буюу 24,8 сая төгрөгийн мэдээллийг байршуулаагүй, 149 мэдээлэл байршуулахаас 1 мэдээллийг хугацаа хоцруулан мэдээлсэн байна.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Шалгагдагч байгууллага нь Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-г мөрдөж ажиллаагүй төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна. Иймд дараагийн аудитаар горим сорил хэрэгжүүлэн анхаарч үзэх шаардлагатай гэж үзэв.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 137.5 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж 109,6 сая төгрөгийн алдааг залруулж, Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-тай холбоотой 1, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 нийт 2 албан шаардлага өгсөн.



4.1.4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Цалингийн зардлыг тулган баталгаажуулахад санхүү үр дүнгийн тайланд 70,4 сая төгрөгөөр,
2. Цалингийн өглөг дансыг тулган баталгаажуулахад мөнгөн гүйлгээний тайланд 34,9 сая төгрөгөөр,
3. ХХАОТ-г тулган баталгаажуулахад өглөгийн дансанд 3,8 сая төгрөгөөр,
4. Эмийн өглөг дансыг тулган баталгаажуулахад бараа материалын тодруулга тайлангийн эмийн тайланд 0,04 сая төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнасан

4.1 4. 2 Албан шаардлага

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.Илрүүлэлт:

Бараа үйлчилгээний зардлаас 3,1 сая төгрөгөөр вакум хаалга, эм худалдан авсан байна

Өгсөн албан шаардлага:

Сангийн сайдын 2021 оны "Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай" 190 дугаар тушаалыг хэрэгжүүлж ажиллах

2.Илрүүлэлт:

1. Шилэн дансны мэдээллийг тулган баталгаажуулахад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 7 гүйлгээ буюу 24,8 сая төгрөгийг мэдээлээгүй, шилэн дансны нэгдсэн системд 149 мэдээлэл байршуулахаас 1 мэдээллийг хугацаа хоцруулан байршуулсан байна

Өгсөн албан шаардлага

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 6 дугаар зүйлийн 6.1.5, 6.4.5-д заасныг хэрэгжүүлж ажиллах

Албан шаардлагын хэрэгжилтийг 2022 оны 5 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газар ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл



№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс таггалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	ТШЗ	5	112,7	1	109,5	0	0	1	3,1	0	0
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	Дүн	5	112,7	1	109,5	0	0	1	3,1	0	0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	ТШЗ	2	24,8	0	0	0	0	1	24,8	0	0
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	Дүн	2	24,8	0	0	0	0	1	24,8	0	0
	НИЙТ ДҮН	7	137,5	1	109,5	0	0	2	27,9	0	0